


ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Сарын тойм: 2017 оны 1 дүгээр сар


Утас: 70114433

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 12,359.83 +6.11% (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



MSE ALL индекс, 852.9 -1.1% (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



МХБ Топ-20 багцад багтах хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэр	XII/31	I/31	Өөрчлөлт
Таван толгой ХК (TTL)	2711	3298	+21.7%
Монгол шуудан ХК (MNP)	339.86	360.21	+6.0%
Талх чихэр ХК (TCK)	18130	19010	+4.9%
Говь ХК (GOV)	10150	10530	+3.7%
УБ-БҮК ХК (BUK)	455	460	+1.1%
Мерекс ХК (MRX)	60	60	0.0%
Ариг гал ХК (EER)	2300	2300	0.0%
Баянгол зочид буудал ХК (BNG)	42000	41160	-2.0%
Дархан нэхий ХК (NEH)	19500	19100	-2.1%
Адуунчулуун (ADL)	1800	1755	-2.5%
Улсын их дэлгүүр ХК (UID)	614	596.25	-2.9%
Сүү ХК (SUU)	128.16	124.01	-3.2%
Багануур ХК (BAN)	2000	1902	-4.9%
Гермес центр (HRM)	169.9	160	-5.8%
Махимпекс ХК (MMX)	2750	2585	-6.0%
Материалпекс ХК (MIE)	9000	8250	-8.3%
АПУ ХК (APU)	396.22	351.74	-11.2%
Ремикон ХК (RMC)	62	55	-11.3%
Шарын гол ХК (SHG)	2750	2400	-12.7%
Хөх ган (HGN)	66.95	53.56	-20.0%

Эх сурвалж: МХБ

Олон улсын индексүүд

Индекс	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт	2016.12.31-тэй харьцуулсан
DJIA (US)	+22.97%	+0.51%
Nikkei 225 (JP)	+9.12%	+1.33%
Hang Seng (HK)	+20.13%	+6.18%
DAX 30 (DE)	+20.40%	+0.47%
SMI (CH)	+2.43%	+1.23%
MSE 20	+6.11%	-0.47%

Эх сурвалж: Блумберг

Валютын ханш

	2016.12.31	2017.01.31	Өөрчлөлт
USD - ТӨГ	2,489.53	2,459.44	-1.21%
EUR - ТӨГ	2,605.79	2,631.48	+0.99%
JPY - ТӨГ	21.19	21.66	+2.22%
CHF - ТӨГ	2,423.37	2,471.67	+1.99%

Эх сурвалж: Монгол Банк

Үнэт цаасны зах зээлийн мэдээ

Хувьцааны арилжаа

МХБ-ээр 2017 оны 1-р сард нийт 2,693.5 сая төгрөгийн дүнтэй арилжаа хийгдэж, 77 компанийн хувьцаа арилжигджээ. Энэ нь өмнөх оны мөн үед хийгдсэн арилжааны дүнтэй харьцуулахад 5.8 дахин их үзүүлэлт байсан бол өмнөх 12-р сард хийгдсэн 1,987.3 сая төгрөгийн арилжааны дүнтэй харьцуулахад 1.4 дахин их дүнтэй байлаа. Энэ сарын арилжааны дүн өмнөх саруудынхаас их үзүүлэлттэй байгаад Тавантолгой ХК, Женко тур бюро ХК-ийн /тус хувьцааны 15% арилжигдсан/ хувьцаа нийт арилжааны 62% буюу 1,678.4 сая төгрөгөөр арилжигдсан нь голчлон нөлөөллөө.

Засгийн газрын үнэт цаасны арилжаа

1-р сард МХБ-ээр 4 удаагийн арилжаагаар нийт 36.5 тэрбум төгрөгийн дүнтэй Засгийн газрын үнэт цаас арилжигдлаа. Энэ нь 1-р сарын нийт үнэт цаасны арилжааны 92.8% эзлэв /сүүлийн 3 сард 97%-аас дээш байв/.



Хүүгийн хэмжээ

28 долоо хоног	17.68 %
39 долоо хоног	18.00 %
52 долоо хоног	17.93 %
156 долоо хоног	18.00 %

МХБ-ийн Топ-20 сагс шинэчлэгдлээ

Монголын хөрөнгийн бирж 2016 оны сүүлийн хагас жилийн арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээг харгалзан ТОП-20 индексийн сагсаа шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 17 компани хэвээр үлдэж, Женко тур бюро ХК, Монголын Цахилгаан Холбоо ХК, Мик холдинг ХК хасагдаж, шинээр Адуунчулуун ХК, Хөх ган ХК, Гермес центр ХК нэмэгдсэн байна.

Эх сурвалж: МХБ

Монгол шуудан ХК-ийн татсан хөрөнгийн зарцуулалт

Монгол шуудан ХК нь 2017/I/25-ны Ээлжит бус хурлаараа IPO хийж татан төвлөрүүлсэн 6.26 тэрбум төгрөгийн зарцуулалтыг шинэчлэх батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Эх сурвалж: Маркетинфо

Хуучин төлөвлөгөөний зарцуулалт	Дүн ₮	Шинэ төлөвлөгөөний зарцуулалт	Дүн ₮
Барилга байгууламж	4,100,000,000	Ялган боловсруулах төв	3,700,000,000
Машин	1,800,000,000	Автопарк шинэчлэл	350,000,000
Тоног төхөөрөмж	178,000,000	Тоног төхөөрөмж, програм	761,000,000
Тавилга эд хогшил	20,000,000	Салбарын байр авах	3,000,000,000
		Ребрэндинг	367,000,000
Нийт дүн	6,098,000,000	Нийт дүн	6,178,000,000

Хувьцаат компаниудын холбоо байгуулагдлаа

2017/I/18-ны өдөр Монголын хувьцаат компаниудын холбоо байгуулагдаж, одоогоор МХБ-д бүртгэлтэй байгаа нийт 206 хувьцаат компанийн нийтлэг эрх ашгийг хамгаалахаар болов. Түүнчлэн, тус холбоо нь хувьцаат компаниудын засаглалыг сайжуурах чиглэлд онцгойлон анхаарч ажиллах юм байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн мэдээ

ҮЦТХТ-өөс [Тавантолгой ХК 2013, 2014 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан](#) ба Гермес центр ХК 2016 оны сүүлийн хагаст нэгж хувьцаанд 4 төгрөгийн ногдол ашиг тараах болсныг мэдэгдлээ. Түүнчлэн, цаашид Эрдэнэ Тавантолгойн хувьцааг МХБ-ээр арилжих тул [иргэдийг хувьцааны дансаа нээлгүүлэхийг анхааруулжээ](#).

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
УБ хот, Чингэлтэй дүүрэг
1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3
Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээг Стандарт инвестмент ҮЦК /Үнэт цаасны компани/ бэлтгэсэн болно. Тойм мэдээнд дурьдагдсан хувьцаат компаниуд болон тэдгээрийн хувьцааны талаарх мэдээлэл, дүгнэлтийг үнэн зөвөөр гаргахыг хичээсэн бөгөөд Стандарт инвестмент ҮЦК-ийн шинжээчдийн өөрсдийн үзэл бодол болно.

Стандарт инвестмент ҮЦК нь Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага юм. Бид иргэд, байгуулагуудад үнэт цаас худалдах, худалдан авахад нь зуучлах, өөрийн нэр дээр үнэт цаас худалдан авах, худалдах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон үйлчилгээ үзүүлэх, андеррайтер болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлдэг.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭ НЬ ЯМАР НЭГЭН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ САНАЛ БИШ ЮМ. ЭНД ДУРДСАН ҮНЭ ХАНШИЙН МЭДЭЭ, БУСАД ТООН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛБАР ЗЭРЭГ НЬ ЗӨВХӨН ТУХАЙН МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭХ ҮЕИЙН БАЙДЛЫГ ИЛТГЭХ БӨГӨӨД ӨӨРЧЛӨГДӨЖ, ХУВЬСАЖ БОЛНО /СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ АЛБАГҮЙ/. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ЭРСДЛИЙГ ӨӨРӨӨ ХАРИУЦНА.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭНИЙ БҮХ МЭДЭЭЛЛИЙГ ЗӨВХӨН МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗОРИЛГООР БЭЛДСЭН БӨГӨӨД НАЙДВАРТАЙ, САЙН САНААНЫ ҮҮДНЭЭС ГАРГАСАН ГЭЖ ҮЗСЭН ЭХ СУРВАЛЖААС АВЧ БОЛОВСРУУЛСАН ХЭДИЙ Ч МЭДЭЭЛЭЛ ТУС БҮРИЙГ НЭГБҮРЧЛЭН ХЯНАЖ ШАЛГААГҮЙ БОЛНО. ТИЙМЭЭС СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК НЬ ЭДГЭЭР МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БОДИТ БӨГӨӨД БҮРЭН БҮТЭН БАЙДАЛД БАТАЛГАА ГАРГАХГҮЙ БӨГӨӨД МЭДЭЭЛЛИЙГ ДАМЖУУЛАХААС ҮҮССЭН АЛИВАА АЛДААГ ХАРИУЦАХГҮЙ. ТҮҮНЧЛЭН, ЭНЭХҮҮ ТАЙЛАНГ АШИГЛАСНААС УЧИРСАН АЛИВАА ХОХИРОЛД СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ЯМАР НЭГЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ.

ЭНЭХҮҮ ТОЙМ БОЛОН СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК-ИЙН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР НЭГЭН ХЭЛБЭРЭЭР ЦААШ НЬ ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ, ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО.

©2017 *Стандарт инвестмент ҮЦК*